

Санхүүгийн хяналт шалгалт хийсэн  
дүнгийн тухай

**НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО**

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/21 дугаар удирдамжийн дагуу Могод сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2022 оны 11 сарын 14-ний өдрөөс хуанлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

**ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

Могод сумын цэцэрлэгийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ  
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Могод сумын нэгдүгээр багт байршилтай 9012079 регистрийн дугаартай 75 хүүхдийн хүчин чадалтай “Оч” цэцэрлэг нь эрхлэгч, үндсэн багш 3, туслах багш 3, тогооч 1, туслах тогооч 1, нярав 1, жижүүр манаач 2, нягтлан бодогч 0.5 нийт 12.5 орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүргэсэн байна.

“Оч” цэцэрлэгийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг 01 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг дуустал П.Энхтүвшин, хоёрдугаар гарын үсгийг 01 сарын 01-ний өдрөөс 02 сарын 28-ны өдрийг хүртэл Г.Мөнхзул, 03 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг дуустал Б.Бадамханд нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100040615201 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100040615402 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг “СТS” программаар бүртгэн хөтөлжээ.

**Тайлант онд** 03 сарын 01-ээс 03 сарын 19-ний өдрийг хүртэл 13 өдөр ажиллаж 768 хүүхэд өдөр, 9 сарын 01-ний өдрөөс 09 сарын 30-ны өдрийг хүртэл 22 өдөр 950 хүүхэд өдөр, 10 сарын 01-ний өдрөөс 10 сарын 30-ны өдрийг хүртэл 22 өдөр ажиллаж

909 хүүхэд өдөр, 11 сарын 01-ний өдрөөс 11 сарын 30-ны өдрийг хүртэл 20 өдөр ажиллаж 964 хүүхэд өдөр, 12 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл 23 өдөр 993 хүүхэд өдөр ажиллаж нийт 100 өдөр ажиллаж 4584 хүүхэд өдөрт 11,379.1 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан байна.

2021 оны 03 сарын 01-ээс 12 сарын 17-ны өдрийг хүртэл 90 өдөр ажиллаж үндсэн 3 бүлэгт нэг өдөрт дунджаар 48 хүүхэд, нэг бүлэгт дунджаар 16 хүүхэд хамруулсан бол 12 сарын 20-ны өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл 10 өдөр үндсэн 3 бүлгээс зөвхөн “Холимог” нэг бүлэг нийт 288 хүүхэд өдөр ажиллаж, нэг өдөрт 29 хүүхэд хамрагджээ.

Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахал гарсаны улмаас 2021 оны 1 сарын 4-ний өдрөөс 2 сарын 28, 3 сарын 22-ны өдрөөс 05 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд тус сумын цэцэрлэгт хүүхэд хамрагдаагүй байна.

Цэцэрлэгийн нягтлан бодогчийн албан тушаалыг сумын ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Г.Мөнхзулд 01 сарын 01-ний өдрөөс 02 сарын 28-ны өдрийг хүртэл хавсран гүйцэтгүүлж үндсэн цалингийн 40 хувиар 565.2 мянган төгрөг, сумын ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Б.Бадамхандад 03 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл хавсран гүйцэтгүүлж үндсэн цалингийн 40 хувиар 3-12-р сард 3,190.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Нярав, эд хариуцагчаар Т.Нэргүй ажиллажээ.

#### **ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Могод сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан гэж байгаа ч гарын үсэггүй, 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, шалгалтын материалыг архивлаагүй, шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.

#### **ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Могод сумын цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд **2021 онд** мэдээлбэл зохих 162 мэдээллээс 159 мэдээллийг тогтоосон хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Мэдээлэл байршуулсан байдлыг шалгахад; өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 13 шийдвэрээс 2021 онд 1 шийдвэр, 2022 оны 1-р сард 7 шийдвэрийг байршуулсан ч PDF форматаар мэдээлээгүй, 5 шийдвэрийг огт байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 12 удаагийн 214,884.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг огт мэдээлээгүй байна.

**2022 оны 1-10-р сард** мэдээлбэл зохих 132 мэдээллээс 123 мэдээллийг тогтоосон хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 15 шийдвэр байршуулсан ч PDF форматаар мэдээлээгүй байна.

#### **ДОЛОО. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

Могод сумын цэцэрлэгийн 2021 оны касс, харилцах, няравын бараа материалын баримт, байгууллагын даргын А, Б тушаал, 3 бүлгийн ирцийн бүртгэл, цагийн бүртгэл, хүнс, бараа материалын агуулахын бүртгэл, санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн карт, эд хөрөнгийн тооллогын бүртгэл зэрэг холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан эрхлэгч

П.Энхтүвшин, нягтлан бодогч Г.Мөнхзул, нярав Т.Нэргүй нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

**7.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:**

**2021 онд** тусгай зориулалтын шилжүүлгээс 222,327.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28,154.4 мянган төгрөг нийт 250,481.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар баталсан.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 192,833.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,050.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 180.0 мянган төгрөг, хүүхдийн хоолны үлдэгдлээс 61 кг хонины мах худалдан борлуулсаны орлого 439.2 мянган төгрөг нийт 215,503.4 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдэж, үйл ажиллагааны зардалд 205,333.8 мянган төгрөгийг зарцуулж, 10,169.6 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

**Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:**

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт + Хэтрэлт-	Төсвийн нийт зардалд эзлэх хувь
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,363.2	134,498.4	+20,864.8	65.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,974.0	17,741.6	+3,232.4	8.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,454.4	21,350.1	+6,104.3	10.4
2104	Хангамж, бараа материалын зардал	5,265.3	8,769.3	-3,504.0	4.3
2105	Нормативт зардал	38,322.2	14,475.3	+23,846.9	7.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	700.0	5,700.0	-5,000.0	2.8
2107	Томилолт, зочны зардал	71.4	0.0	+71.4	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	326.1	794.1	-468.0	0.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,505.3	1,505.0	+0.3	0.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	500.0	500.0	-	0.2
	<b>Дүн</b>	<b>250,481.9</b>	<b>205,333.8</b>	<b>+45,148.1</b>	<b>100</b>

Дэлхий нийтэд Ковид 19 цар тахал гарч хөл хорио тогтоосноор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа түр зогссонтой холбоотойгоор илүү цагийн хөлс олгогдоогүй, хоолны зардал болон бусад төсөвт зардал хэмнэгдэхэд нөлөөлжээ.

**Нэмэлт төсөв:** 2021 онд аймгийн Боловсрол соёл урлагийн газар /хуучин нэрээр/- аас орсон ариутгал халдваргүйжүүлэлтийн 180.0 мянган төгрөгийн орлогыг оны эцэст татан төвлөрүүлсэн байна.

**7.2 Өглөг, авлагын талаар:**

2021 онд өглөггүй. Авлагын хувьд Улаанбаатар хотын Битачи ХХК-иас авах хүүхдийн сургалтын тоглоомын 4,499.5 мянган төгрөгийн авлагаас 2,758.0 мянган төгрөгийг барагдуулж оны эцэст 1,741.5 мянган төгрөгийн авлагатай байна.

### 7.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж, орон сууц	428,757,074.00	0.00	0.00	428,757,074.00
2	Машин тоног төхөөрөмж	37,735,139.04	2,200,000.00	0.00	39,935,139.04
3	Тавилга, эд хогшил	22,006,578.46	2,800,000.00	0.00	24,806,578.46
4	Номын фонд	3,659,707.00	0.00	0.00	3,659,707.00
5	Бусад үндсэн хөрөнгө	8,390,000.00	0.00	0.00	8,390,000.00
6	Программ хангамж	1,600,000.00	0.00	0.00	1,600,000.00
7	Бусад биет бус хөрөнгө	12,666,000.00	0.00	0.00	12,666,000.00
	<b>Дүн</b>	<b>514,814,498.50</b>	<b>5,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>519,814,498.50</b>

Эгшиглэнмагнай ХХК-иас 750.0 мянган төгрөгөөр 3 ширхэг мандалин хөгжим, Их жээт ХХК-иас 990.0 мянган төгрөгөөр 2 ширхэг зургаан хаалгатай шкаф, Могод тариат ХХК-иас 600.0 мянган төгрөгөөр 2 ширхэг сандал, 150.0 мянган төгрөгөөр тумбочек, 200.0 мянган төгрөгөөр үүдний тек, 1,450.0 мянган төгрөгөөр өнгөт принтер, 490.0 мянган төгрөгөөр бичгийн ширээ, 370.0 мянган төгрөгөөр уулзалтын ширээ нийт 5,000.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

### 7.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	526,200.00	1,110,250.00	1,210,850.00	425,600.00
2	Аж ахуйн материал	1,938,900.00	2,202,300.00	2,665,700.00	1,475,500.00
3	Түлш, шатах тослох	1,300,000.00	978,500.00	1,628,500.00	650,000.00
4	Хоол, хүнс	3,142,446.00	12,002,500.00	11,818,262.00	3,326,684.00
5	Эм, боох материал	1,049,800.00	1,002,400.00	1,259,200.00	793,000.00
6	Бусад хангамж	33,145,894.00	10,753,300.00	7,392,050.00	36,507,144.00
7	Нөөц бараа	0.00	210,000.00	210,000.00	0.00
	<b>Дүн</b>	<b>41,103,240.00</b>	<b>28,259,250.00</b>	<b>26,184,562.00</b>	<b>43,177,928.00</b>

Бараа материалыг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, бараа материал актлаагүй, жилийн эцэст 43,177.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлан баланс гаргасан байна.

### **ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ**

Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь үндсэн хөрөнгө, бусад хангамжийн материалын дансанд бүртгэлтэй хөрөнгө бараа материалын зургийг өнгөтөөр гаргаж, тухайн хөрөнгийн ашиглалтад орсон он, хариуцсан эд хариуцагчдын нэр, эд хөрөнгийн нэр тус бүрээр бүртгэл хөтөлж, бүртгэлжүүлсэн ололттой тал байна.

### **ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН,**

## **ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ**

1. Шаардах хуудас, хоолны өдөрлөг, орлогын баримт дугааргүй, орлогын баримтыг нэг хувь үйлддэг, шаардах хуудаст зарлагын баримт үйлдээгүй, хүнс, бараа материалын агуулахын бүртгэлд зарлагадсан хүнс бараа материалыг хаана хэнд олгосон утга, баримтын дугаарыг тавилгүй маягтыг дутуу хөтөлсөн, цагийн бүртгэлд цаг бүртгэгчийн гарын үсэг зурагдаагүй, 6 дугаар сараас 08 сарыг дуустал ажиллагсдын цагийг бүртгээгүй, нягтлан бодогч няравын гаргасан хүнс, бараа материалын тайланг шалгаж хүлээн авсан ч тооцоог бодож акт үйлдээгүй.

2. Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй, хөрөнгө нэг бүр дээр эд хариуцагчийн гарын үсэг зурагдаагүй.

3. Зарцуулагдаагүй үлдсэн хүнсний материалаас 61 кг хонины мах сумын иргэнд худалдан борлуулахдаа анхан шатны баримт үйлдээгүй хүлээлгэн өгсөн.

4. Бүлгийн багш нараас 2 багш ирцийн бүртгэлийг арилгадаг балаар бүртгэсэн.

5. Тус сумын Засаг даргын 2021 оны 04 сарын 22-ны Б/15, 2021 оны 06 сарын 16-ны Б/20, 11 сарын 01-ний өдрийн Б/27, 2021 оны 12 сарын 16-ны өдрийн Б/29 дугаар захирамжаар Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн эрхлэгч П.Энхтүвшинд 1, 2, 3, 4-р улиралд үндсэн цалингийн 30-45 хувиар тооцож 1,459.4 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон атал сумын Засаг даргын 2021 оны 12 сарын 16-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар дээрх эрх зүйн актыг үндэслэн “2021 оны жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлэн, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг харгалзан нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор” гэж эрхлэгч П.Энхтүвшинд үндсэн цалингийн 40 хувиар буюу 364.8 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон

6. Шилэн дансны нэгдсэн сайтад 2021 онд 3 мэдээлэл, 2022 онд 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмч хөрөнгөтэй холбоотой 13 шийдвэрээс 5 шийдвэрийг байршуулаагүй, 8 шийдвэрийг байршуулсан ч PDF форматаар мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 12 удаагийн 214,884.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг огт мэдээлээгүй.

## **АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын ахлах байцаагчийн 1 актаар 162.0 мянган төгрөгийн төлбөр тогтоож, зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 албан шаардлага үйлдэж, байгууллагын удирдлага болон санхүү, бүртгэлийн 2 албан хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Нярав Т.Нэргүйг байлцуулан 2022 оны 11 сарын 17-ны өдөр цэцэрлэгийн хүнсний үлдэгдэл, хүүхдийн ирцэд биет тооллого хийхэд; гурил, элсэн чихэр, мах, масло, ургамлын тос, пүнтүүз, лууван, байцаа, төмс 9 нэр төрлийн хүнсний материал биет тооллогоор агуулахын үлдэгдэлтэй, ирсэн хүүхдийн тоо багшийн журналаар бүртгэсэн хүүхдийн тоотой таарсан. 2 бүлгийн багш ирцийн журналыг арилгадаг балаар бүртгэсэн байв.

## **ДҮГНЭЛТ**

Тус сумын цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

#### ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох тушаал, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, төлбөрийн актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН



